



СПОРТЫН ЗАДГАЙ ТАЛБАЙ

1. Спортын задгай талбай байгуулах саналыг ИТХ-д оруулж, орон нутгийн хөгжлийн сангаас 6,1 сая төгрөгийг батлуулсан.

2. Талбай барихад шаардлагатай нэмэлт 5 сая төгрөгийг орон нутгийн “Яагд энд тур” ХХК хандивласан. Сумын иргэд өөрсдөө санаачилан хандив босгож, талбайн 4 талд гэрэлтүүлэг хийсэн.

3. Сумын гарын дүйтэй, чадварлаг таван иргэн тохижилтын бүх ажлыг хийж гүйцэтгэсэн.



Харилцах хаяг: Завхан аймгийн Шилүүстэй сумын Засаг дарга Д.Алтанжаргал, Утас: 8001-5039

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



ДҮҮРГҮҮДЭД ЖИШИГ НОМЫН САН, УНШЛАГЫН ТАНХИМ АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ

1. 2018-2019 онд нийт зургаан дүүрэгт нийслэл, дүүргийн өмчийн үл хөдлөх талбайг ашиглан иргэнд ойрхон уншлагын танхимууд байгуулсан.

2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэлэлцэх үеэр иргэдэд ойр номын сан байгуулах тухай саналаа бусад төлөөлөгчдөд ойлгуулан, бодлогын бичиг баримтанд тусгуулж чадсан.

3. Төсвийн төсөл дээр “номын сан, уншлагын танхимыг дүүрэг бүрт байгуулах” гэж тодорхойлон тусгуулж чадсанаар 2018-2020 оны хооронд Нийслэлийн дүүрэг болгон номын сан, уншлагын танхимтай болох боломж бүрдсэн.



Харилцах хаяг: Ц.Байгалмаа, НИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч
Утас: 9910-5320, И-мэйл хаяг: Baigal.t@gmail.com



БИОХИМИЙН ИЖ БҮРЭН ШИНЖИЛГЭЭГ ЯАРАЛТАЙ ХИЙХ БОЛОМЖ

1. Биохимийн шинжилгээг тойргийнх нь 5 сумын иргэд Дархан, Сэлэнгийн төв болон УБ хотод хийлгэдэг байсныг өөрчилж, яаралтай тохиолдолд сумынхаа эмнэлэг дээр биохимийн иж бүрэн шинжилгээ хийж болох шийдвэрийг ИТХ-аас гаргуулсан.

2. Ингэснээр яаралтай тусламж шаардлагатай иргэд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд иж бүрэн шинжилгээ өгөхийн тулд хол газрыг зорих шаардлагагүй болсон.

3. Шийдвэр гаргахын өмнө иргэдийн оролцоог баталгаажуулах механизм буюу Нийтийн сонсголын арга хэрэгслийг хэрэглэсэн.



Харилцах хаяг: Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ИТХ-ын төлөөлөгч тэргүүлэгч, Хөтөл сум дундын эмнэлэгийн амбулаторийн эрхлэгч Ч.Бүүлхагва, Утас: 9936-3202



ДУЛААЛГЫН АЯН-ЗАГВАР ӨРХ

1. 9000 янданг буулгаж, гэр хороололд тухтай, эрүүл амьдрах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Дулаалгын аян”-ыг санаачилсан.



2. Хороодоос сонгогдсон 13 загвар өрхийн амины орон сууцны дулаан алдалтыг багасгаснаар хоногт хэрэглэх түүхий нүүрсний хэрэглээг 60-75 хувиар бууруулсан.



Харилцах хаяг: Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, дүүргийн Засаг даргын төсөл хариуцсан орлогч дарга Ж. Чимэлцогзол Утас: 9914-1307, И-мэйл хаяг: chimedtsogzol1223@gmail.com



МӨНГӨ ИДДЭГ ТООЛУУР

1. Иргэдийн цахилгааны зардал өндөр гарч байгаа шалтгааныг илрүүлэн, хэмнэлттэй хэрэглээг бий болгосон.

2. Хяналт шалгалт хийж иргэдэд бодит байдлыг танилцуулснаар цахилгааны төлбөрийн талаарх иргэдийн гомдол багасч, айл өрхийн сар бүрийн цахилгааны зардал бага гардаг болжээ. Жишээ нь, нэг айл өрх сардаа 3000-6000 төгрөг, жилдээ 72000-аас дээш төгрөгийг цахилгааны зардлаасаа хэмнэдэг болсон байна.



Харилцах хаяг: Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-ын төлөөлөгч Ё.Ариунжаргал, Утас: 8999-8740,
Завхан аймгийн Их-Уул сумын ИТХ-ын төлөөлөгч Г.Жавзансүрэн, Утас: 9303-2529




“ХИЙЦТЭЙ ЦАЙ” АЯН

1. Эмэгтэй төлөөлөгчдийн санаачилгаар зорилтот бүлгийн өрхийг нийгмийн харилцаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хийцтэй цай” аянг зохион байгуулсан.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, өрх толгойлсон эцэг эх, амьжиргааны түвшин доогуур өрх зэргээр ялгаатай хэрэгцээг тодорхойлон, шаардагдах тусламж, үйлчилгээг хүргэсэн.

3. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчидтэй хамтарсан.



Харилцах хаяг: Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ИТХ-ын Нарийн бичгийн дарга Т.Бэрцэцэг
Утас: 8606-8184, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Багийн ИНХ-ын тэргүүлэгч, Сумын Хөдөлмөр Халамжийн мэргэжилтэн Ц.Уянга, Утас: 9829-2960



СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНД 130 САЯ ТӨГРӨГ ТӨВЛӨРҮҮЛЭВ

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, эргэлтийн хөрөнгөгүй болсон байсан.

2. Эмэгтэй төлөөлөгчдийн санаачилгын дагуу ИТХ-аас хяналт шалгалтын ажлын хэсэг томилогдож, Сум хөгжүүлэх санд төлөгдөөгүй байсан 130 сая төгрөгийг 2018 оны 11 сард татан төвлөрүүлж чадсан.



*Харилцах хаяг: Увс аймаг Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч Дариймаа, Булгамаа
Төлөөлөгч Ж. Энхтуяа, Ц.Сурвалжлагч, С. Дэлгэртөгс, Ш.Алтансүх, З.Нина, Б.Туяа нар Утас 99455512,
И:мэйл: ug.khural@gmail.com*

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН САНААЧИЛГААР 4 БАГ ЦЭЦЭРЛЭГИЙН БАЙРТАЙ БОЛЖЭЭ

1. Хөдөөгийн дөрвөн баг цэцэрлэгийн байртай болсноор малчдын хүүхдүүд хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсролыг бүрэн эзэмших тав тухтай орчин бүрдсэн.

2. Гэрт сургалт явуулдаг байхад нэг багт 10-12 хүүхэд л сурах боломжтой байсан бол байртай болсноор баг болгонд цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийн тоо 2 дахин нэмэгджээ.

3. Цэцэрлэг барихад шаардагдсан 28 сая төгрөгийг сумын ИТХ-ын төлөөлөгчид ба иргэдийн хандиваар босгосон.



Харилцах хаяг: Увс аймаг Өндөрхангай сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга А. Даваажаргал
Утас: 94176161, 98617977, 90167977, и-мэйл хаяг: davaajargal@khural.uv.gov.mn

НУТГИЙН УДИРДЛАГАД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ

Эмэгтэй төлөөлөгчдийн сайн туршлага



207 ХҮҮХЭД, 682 ИРГЭДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД ХАМГААЛАГДЛАА

1. Олон талт санхүүгийн эх үүсвэрээс 12 сая 990 мянган төгрөгийн санхүүжилт босгож, Тарнын гол дээр гүүр бариулсан.

2. Төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэгтгэж чадсан.

3. Голын ус гаталж чадахгүйгээс шалтгаалсан саад арилж, иргэд жилийн дөрвөн улиралд, цаг агаарын ямар ч нөхцөлд чөлөөтэй зорчих боломжтой болсон.

4. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчтэй хамтран ажилласан.



*Харилцах хаяг: Булган аймгийн Гурванбулаг сум 6-р баг
ИТХ-ын Төлөөлөгч Цэндбазарын Даваажав Утас-9633-5334*

